

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/166/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Назгүл
Утас: 88403281 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ТТӨХ	Тоног төхөөрөмж

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			Төгрөгөөр	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,335,551.00</u>	<u>3,214,361.00</u>	
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	
33	АВЛАГА	-	810,150.00	
335	Бусад авлага	-	810,150.00	
3351	Байгууллагаас авах авлага	-	810,150.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	7,335,551.00	2,404,211.00	
354	Хангамжийн материал	7,335,551.00	2,404,211.00	
35410	Бичиг хэргийн материал	5,100.00	570,000.00	
35420	Аж ахуйн материал	7,330,451.00	1,814,211.00	
35460	Хүнсний материал	-	20,000.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>43,454,181.84</u>	<u>64,259,717.26</u>	
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	43,454,181.84	64,259,717.26	
391	Газар			
392	Биет хөрөнгө	43,454,181.84	63,310,891.30	
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,837,203.28	3,837,203.28	
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,279,068.00)	(1,534,881.60)	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,000,000.00	62,280,200.00	
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,833,333.31)	(28,165,058.27)	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,684,450.00	35,691,350.00	
39206	Хуримтлагдсан элэгдэл	(12,900,812.46)	(19,693,031.53)	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,288,175.00	40,166,625.00	
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,342,432.67)	(29,271,515.58)	
393	Биет бус хөрөнгө	-	948,825.96	
39301	Програм хангамж	850,000.00	1,423,239.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	(850,000.00)	(474,413.04)	
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>50,789,732.84</u>	<u>67,474,078.26</u>	
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>50,789,732.84</u>	<u>67,474,078.26</u>	
51	Засгийн газрын хувь оролцоо	50,789,732.84	67,474,078.26	
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	158,734,618.96	158,734,618.96	
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	158,734,618.96	158,734,618.96	
512	Хуримтлагдсан үр дүн	(117,510,574.52)	(100,826,229.10)	
51210	Өмнөх үеийн үр дүн	(117,510,574.52)	(75,230,374.52)	
51220	Тайлант үеийн үр дүн	-	(25,595,854.58)	
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс			
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,565,688.40	9,565,688.40	

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>50,789,732.84</u>	<u>67,474,078.26</u>
---	--	-----------------------------	-----------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,308,429,100.00	1,352,021,139.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,600,000.00	8,778,239.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	8,778,239.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	8,778,239.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		8,778,239.00
122	Тусламжийн орлого	2,600,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	2,600,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,305,829,100.00	1,343,242,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	651,700,000.00	248,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	651,700,000.00	248,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	654,129,100.00	1,095,242,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	654,129,100.00	1,095,242,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,302,982,005.28	1,371,155,753.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,302,982,005.28	1,371,155,753.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,302,735,526.66	1,289,483,634.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,012,655.94	481,956,085.19
210101	Үндсэн цалин	193,739,254.71	265,777,664.79
210102	Нэмэгдэл	71,716,800.57	185,113,013.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,617,514.66	10,728,644.61
210104	Урамшуулал	19,939,086.00	20,336,761.86
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,060,965.44	59,069,500.00
210201	Тэтгэврийн даатгал	25,472,160.26	40,167,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,961,015.83	4,725,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,368,813.76	2,362,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	568,996.85	2,362,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,689,978.74	9,451,100.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	29,476,000.00	27,334,138.00
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	3,459,550.00
210402	Тээвэр, шатахуун	23,500,000.00	21,091,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,976,000.00	2,783,288.00
2105	Нормативт зардал	1,024,000.00	1,020,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,024,000.00	1,020,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,146,720.00	9,791,070.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	9,791,070.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	42,146,720.00	-
2107	Томилолт, зочны зардал	14,500,000.00	17,117,200.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	14,500,000.00	17,117,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,957,000.00	6,359,740.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	4,767,340.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,471,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	135,000.00	99,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	21,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	865,558,185.28	686,835,901.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	845,714,025.00	592,099,748.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,579,975.00	60,753,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,264,185.28	33,982,853.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,478.62	81,672,118.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	80,321,414.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	80,321,414.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	246,478.62	1,350,704.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	246,478.62	1,350,704.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>5,447,094.72</u>	<u>(19,134,614.58)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	6,461,240.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		771,900.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал		5,689,340.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(6,461,240.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>5,447,094.72</u>	<u>(25,595,854.58)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,305,829,100.00</u>	<u>1,343,242,900.00</u>

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,305,829,100.00	1,343,242,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	651,700,000.00	248,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	651,700,000.00	248,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	654,129,100.00	1,095,242,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	654,129,100.00	1,095,242,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,289,717,820.00	1,339,512,950.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,289,717,820.00	1,339,512,950.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,289,471,341.38	1,257,840,831.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,012,655.94	474,707,925.19
210101	Үндсэн цалин	194,485,411.18	258,529,504.79
210102	Нэмэгдэл	71,716,800.57	185,113,013.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,617,514.66	10,728,644.61
210104	Урамшуулал	19,192,929.53	20,336,761.86
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,060,965.44	59,069,500.00
210201	Тэтгэврийн даатгал	25,472,165.26	40,167,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,961,010.83	4,725,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,368,812.76	2,362,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	568,997.85	2,362,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,689,978.74	9,451,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,500,000.00	33,138,298.00
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	5,015,550.00
210402	Тээвэр, шатахуун	23,500,000.00	25,339,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,783,288.00
2105	Нормативт зардал	1,024,000.00	1,020,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,024,000.00	1,020,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,146,720.00	9,791,070.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	9,791,070.00
210604	Урсгал засвар	42,146,720.00	-
2107	Томилолт, зочны зардал	14,500,000.00	17,927,350.00
210702	Дотоод албан томилолт	14,500,000.00	17,927,350.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,957,000.00	6,359,740.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	4,767,340.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,471,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	135,000.00	99,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	21,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	852,270,000.00	655,826,948.00

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	841,970,000.00	595,650,248.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,300,000.00	60,176,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,478.62	81,672,118.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	80,321,414.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	80,321,414.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	246,478.62	1,350,704.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	246,478.62	1,350,704.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>16,111,280.00</u>	<u>3,729,950.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,111,280.00	3,729,950.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,111,280.00	3,729,950.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,111,280.00	3,729,950.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,111,280.00	3,729,950.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(16,111,280.00)</u>	<u>(3,729,950.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	(145,157,669.24)		23,142,638.12
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	(145,157,669.24)	-	23,142,638.12
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	27,647,094.72	-	27,647,094.72
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	(117,510,574.52)	-	50,789,732.84
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	(117,510,574.52)	-	50,789,732.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	42,280,200.00	-	42,280,200.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	(75,230,374.52)	-	93,069,932.84
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	(25,595,854.58)	-	(25,595,854.58)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	(100,826,229.10)	-	67,474,078.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,325,716,600.00	1,093,892,195.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,325,716,600.00	1,093,892,195.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,244,807,800.00	1,013,570,781.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	480,555,300.00	474,707,925.19
210101	Үндсэн цалин	275,433,400.00	258,529,504.79
210102	Нэмэгдэл	170,374,300.00	185,113,013.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,330,500.00	10,728,644.61
210104	Урамшуулал	23,417,100.00	20,336,761.86
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,069,500.00	59,069,500.00
210201	Тэтгэврийн даатгал	40,167,200.00	40,167,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,725,600.00	4,725,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,362,800.00	2,362,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,362,800.00	2,362,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,451,100.00	9,451,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,506,000.00	33,138,298.00
210401	Бичиг хэрэг	5,981,000.00	5,015,550.00
210402	Тээвэр, шатахуун	29,620,000.00	25,339,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,905,000.00	2,783,288.00
2105	Нормативт зардал	1,177,200.00	1,020,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,177,200.00	1,020,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,943,000.00	13,521,020.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,943,000.00	13,521,020.00
2107	Томилолт, зочны зардал	19,810,000.00	17,927,350.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	19,810,000.00	17,927,350.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,786,800.00	6,359,740.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,905,000.00	4,767,340.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	294,300.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,471,500.00	1,471,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	132,400.00	99,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	21,600.00	21,600.00

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,962,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	621,960,000.00	407,826,948.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	560,150,000.00	347,650,248.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,810,000.00	60,176,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,908,800.00	80,321,414.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,908,800.00	80,321,414.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	80,908,800.00	80,321,414.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,325,716,600.00	1,093,892,195.19
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,325,716,600.00	1,093,892,195.19
132001	Орон нутгийн төсвөөс	1,325,716,600.00	1,093,892,195.19
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	15.00	15.00
620001	Удирдах ажилтан	4.00	4.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	15.00	15.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.00
650010	Гэрээт ажилтан		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	651,700,000.00	248,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	651,700,000.00	248,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	651,700,000.00	248,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	651,700,000.00	248,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	248,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	651,700,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	651,700,000.00	248,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	651,700,000.00	248,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	651,700,000.00	248,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Аймгийн ИТХ нь орон нутгийн хөгжлийн бодлого, чин хандлагыг тодорхойлох, аймгийн эдийн засаг, нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэх, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалтыг бүх талаар хөгжүүлж түүний ил тод нээлттэй байдлыг хангах, хурлын хяналтын тогтолцоог улам боловсронгуй болгож үр нөлөөг дээшлүүлэх, ИТХ-ын төлөөлөгч нь сонгогчидтойгоо байнгын харилцан ажиллагаатай байж тэдний эрх ашгийг төлөөлөн илэрхийлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант онд “Иргэд, сонсогчдынхоо эрх ашгийг хамгаалж, эрүүл, аюулгүй амар тайван ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Монгол Улсын үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Улсын Их хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Байгууллагын даргын 2023 оны 01 дугаар сарын 05-ны өдрийн Б/01 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16.5 сая төгрөгөөр буюу 32.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	-	810,150.00	810,150.00
Бараа материал	7,335,551.00	2,404,211.00	(4,931,340.00)
Үндсэн хөрөнгө	43,454,181.84	64,259,717.26	20,805,535.42
Нийт хөрөнгө	50,789,732.84	67,474,078.26	16,684,345.42
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	50,789,732.84	67,474,078.26	16,684,345.42
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	50,789,732.84	67,474,078.26	16,684,345.42

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна. Авлагын данс өмнөх оноос 0.8 сая төгрөгөөр өссөн нь МИАТ ХК-аас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2.4 сая төгрөг болж 4.9 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 79.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 77.6 сая бараа материалыг зарцуулж, 5.7 сая төгрөгийн бараа материалыг ИТХ-ын нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/62 тоот тушаалаар акталж, 0.8 сая төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгөд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 20.4 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 2.6 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, 0.8 сая төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгөд бүртгэж, 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/505 захирамжаар 5.5 сая төгрөгийн 5 нотебүкийг үнэгүй авч, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын дагуу байгууллагын автомашины дахин

үнэлгээний зөрүү 42.3 сая төгрөгөөр нэмэгдэж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжгүй болсон 4.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор данс бүртгэлээс хасаж акталсантай холбоотой байна.

Өглөгийн данс үлдэгдэлгүй байна. Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнгээр 16.7 сая төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1193.0 сая төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр, зарлагын нийт дүнг 1193.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 221 дугаар хуралдааны тогтоолоор 978.2 сая төгрөгөөр баталж, 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 257 дугаар тогтоолоор 1301.6 сая, 09 дүгээр сарын 24-ний өдрийн 262 дугаар тогтоолоор 1325.7 сая төгрөгөөр тус тус тодотгож баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны төсвийн хэлбэлзлийн тайлангаар зарцуулах төсөв нь 1093.9 сая төгрөг байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1325.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1093.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1093.9 сая төгрөг буюу 82.5 хувьтай байгаа нь 230.4 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, 1.4 сая төгрөгийн санхүүжилтийг төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,107,467.80	884,302.40	223,165.40	79.85
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	80,908.80	80,321.40	587.40	99.27
3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал	137,340.00	129,268.40	8,071.60	94.12
	Нийт дүн	1,325,716.60	1,093,892.20	231,824.40	82.51

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь ахмадын сан байгуулаагүй байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажилласан байна. Төсвөөс 2024 онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн /210801/ төсвөөс 4.7 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардлын /210901/ төсвөөс 595.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Тус байгууллагад 2024 онд 15 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр удирдах ажилтан 2, гүйцэтгэх ажилтан 11, үйлчлэх ажилтан 2, нийтдээ 15 орон тоогоор батлагдсан орон тоо, төсөвт багтаан ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 248.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч 240.0 сая төгрөгийг цагаатгалын зардалд, 0.2 сая төгрөгийг албан томилолтын зардалд, 1.4 сая төгрөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд, 5.0 сая төгрөгийг Хилийн цэргийн 0165 дугаар ангид шилжүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгууллага нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал батлагдсан төсвийн хүрээнд 79.2 сая төгрөгийн бараа материал, 3.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, Ховд аймгийн тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02/24 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1303.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 19.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,369.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 20.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илрэв. Үүнд:

1.Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын суудлын нэг автомашиныг өмнөх онд Орон нутгийн өмчийн газарт шилжүүлж данснаас хассан бөгөөд уг автомашины жолоочийг 2024 онд сул ажиллуулж төсвөөс 20.1 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал,

2.Байгууллагын даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн Б/09 дугаар тушаалаар Хяналт шинжилгээ, олон нийттэй харилцах хэлтсийн иргэний оролцоо, олон нийттэй харилцах ажилтныг хууль бус томилж 2024 оны 12 дугаар сарын Б/19 дугаар тушаалаар үүрэгт ажлаас нь чөлөөлсөн ба ажиллах хугацаанд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд төсвөөс 13.0 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 1,303.4 сая төгрөгийн 12 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 498.3 сая төгрөгийн 23 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 323.6 сая төгрөгийн 54 мөнгөн гүйлгээг шалгаж үзэхэд цалингийн зардлаас бусад орлого зардлын 4.9 сая төгрөгийн, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 13.2 төгрөгийн 10 шийдвэрийг байршуулаагүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 85 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах зөвлөмж өгөв..

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 87.7 сая төгрөгийн зөрчил илэрч 17.1 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 70.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд зөрчлийг бүрэн арилгаж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	17,135.3	1	17,135.3	100
Зөвлөмж	3	70,615.8	2	49,615.8	70.2
Нийт дүн	4	87,751.1	3	66,751.1	85.1

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цаг хугацааны хязгаарлалттай байдлаас болж 5 жил тутамд нэг удаа олгох тэтгэмжийн зарцуулалт, хичээл үйлдвэрлэл, дадлагын зардлын зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар төсвийн зарцуулалтыг болон орон тоог дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд нийт 15,134.5 мянган төгрөгийн алдаа илэрч залруулга хийгдсэн. Үүнд:

1. Өмнөх онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар авсан нотебүүк, принтер, санхүүгийн программын үнийг 1756.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж ирүүлснийг залруулав.

2. Үр дүнгийн тайланд орон нутгаас авсан санхүүжилтийг 7412.6 мянган төгрөгөөр дутуу, төвлөрүүлсэн хөрөнгийг 7000.0 мянган төгрөгөөр илүү, дотоод албан томилолтын зардлыг 412.6 мянган төгрөгөөр, татан төвлөрүүлэлтийг 7000.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. Мөнгөн гүйлгээний тайлангийн НДШ, тээвэр шатахууны зардал, багаж хэрэгслийн зардлыг 2776.6 мянган төгрөгөөр дутуу, цэвэр мөнгөн гүйлгээг 2776.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулсан.

3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд гүйцэтгэлийн орлогыг 412.6 мянган төгрөгөөр, нийт зарлагын дүнг 236.9 мянган төгрөгөөр илүү тайлагнаж ирүүлснийг залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 182,929.6 мянган төгрөгийн зөрчил илэрч 496.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 164,288.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 18,145.1 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитын дүнгээр 496.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны жолоочид 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн Б/03, 2024 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн Б/06 дүгээр тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан боловч сахилгын шийтгэлтэй хугацаа дуусаагүй байхад 2024 оны 10 дугаар сард 50 хувийн буюу 496.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг хууль бус олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 2 дахь хэсэг 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасныг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр 164,288.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв. Үүнд:

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, "Амикус" ХХК-тай 2024 оны 07 дугаар сарын 16-ний өдөр ТУР24/84 дугаар, 08 дугаар сарын 06-ний өдрийн ТУР24/8/15 дугаар “Туршлага солилцох гэрээ”-г тус тус байгуулж Бүгд Найрамдах Турк улсын Истанбул, Анталья, Памуккале хотуудад 2024 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс 08 дугаар сарын 11, 08 дугаар сарын 11-ний өдрөөс 08 дугаар сарын 22-ний өдрийн хооронд туршлага судлах нэрийдлээр аймгийн ИТХ-ын 19 төлөөлөгч, ажлын албаны 3 албаны ажилтан нийт 22 хүний бүрэлдэхүүнтэй багийг аяллын зардалд 119,220.0 мянган төгрөгийг, Улаанбаатар-Өлгий хоорондын автобусны замын зардалд 1,300.0 мянган төгрөгийг, нийт 120,520.0 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.2.3-т “хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх”, 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын суудлын нэг автомашиныг өмнөх онд Орон нутгийн өмчийн газарт шилжүүлж данснаас хассан бөгөөд уг автомашины жолоочийг 2024 онд сул ажиллуулж төсвөөс 20,064.3 мянган төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал гаргасан,

Байгууллагын даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн Б/09 дугаар тушаалаар Хяналт шинжилгээ, олон нийттэй харилцах хэлтсийн иргэний оролцоо, олон нийттэй харилцах ажилтныг хууль бус томилж 2024 оны 12 дугаар сарын Б/19 дугаар тушаалаар

үүрэгт ажлаас нь чөлөөлсөн ба ажиллах хугацаанд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд төсвөөс 13,038.1 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар 15.1.2-т “чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 18,134.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахимд байршуулах цалингийн зардлаас бусад орлого зардлын 4915.9 мянган төгрөгийн, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 13229.1 мянган төгрөгийн 10 шийдвэрийг байршуулаагүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 85 хувьтай байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ...” , 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” заасны дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж ажиллах, өмч, хөрөнгө зарцуулсан тушаалыг шилэн дансанд нөхөж байршуулах.

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Бусад бараа үйлчилгээний зардлын төсвөөс хоолны үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, томилолт зэрэгт нийт 10,666.2 мянган төгрөгийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулж, тооцоог зохих журмаар хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-д “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна”, 20.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна

2.1 Өгсөн зөвлөмж:

Хууль журмыг мөрдөж ажиллаж, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхийг таслан зогсоох;

Дээрх зөвлөмж болон бусад шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланг алдаатай гаргасан	1	3,189.3			1	3,189.3	1	3,189.3				
Үр дүнгийн тайланг алдаатай гаргасан	1	10,189.3			1	10,189.3	1	10,189.3				
Үндсэн хөрөнгийн тодруулга тайланг алдаатай гаргасан	1	1,756.0			1	1,756.0	1	1,756.0				
Дүн	3	15,134.5			3	15,134.5	3	15,134.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

									туш аал тны тоо		
Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон	1	496.0	1	496.0							
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулалт хийсэн	1	10,666.2				1	10,666.2				
Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн гадаад аяллын зардалд төсвөөс үргүй зардал гаргасан	1	120,520.0			1	120,520.0					
Дүн	3	131,682.1	1	496.0	1	120,520.0	1	10,666.2			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй байна.	1	18,145.1					1	18,145.1
Дүн	1	18,145.1					1	18,145.1
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цалин зардлын төсвөөс үр ашиггүй хууль бус зардал гаргасан	1	33,102.4			1	33,102.4		
Дүн	1	33,102.4			1	33,102.4		
Нийт дүн	2	51,247.5			1	33,102.4	1	18,145.1